



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА Л.ЦЭДЭВСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2026.06.16 № 34

Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх,  
хяналт тавих талаар

Төсвийн байгууллагуудын удирдлага солигдох, бүтцийн өөрчлөлт хийх бүрд өөрийн болон ойрын хамаарал бүхий этгээдийг ажилд авахын тулд ажилтныг үндэслэлгүй ажлаас халах тохиолдол олон байна. Ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн иргэн ажилгүй байсан хугацааны цалингаа ажил олгогчоос нэхэмжлэн авдаг. Тухайн байгууллага нь үүнийг авлагаар бүртгэж буруутай этгээдээр нөхөн төлүүлэх ёстой ч хууль хэрэгжүүлдэггүй эс үйлдэхүйн улмаас төрд их хэмжээний хохирол учруулж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн танд дараах асуултыг тавьж байна.

1.2024-2026 оны 5 дугаар сар хүртэлх хугацаанд ажилтныг үндэслэлгүй халсан нь шүүхээр тогтоогдсон иргэн, албан тушаалтны талаарх дэлгэрэнгүй (шүүхийн шийдвэр тус бүрээр) тоон мэдээлэл;

2.Сүүлийн 10 жилийн хугацаанд төрд учруулсан хохирол, эргэн төлөлт, үлдэгдлийн талаарх дэлгэрэнгүй тоон мэдээлэл болон хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих талаар хуулийн хэрэгжилттэй холбоотой авч буй арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг он тус бүрээр.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дугаар зүйлийн 11.2-т заасан хугацаанд хариу ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



ДАВ.ЦОГТБААТАР

2026000006